



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2019 оны 07 сарын 31 өдөр

Дугаар А/482

Улаанбаатар хот

Тэтгэлэгт хөтөлбөрөөр гадаадад
суралцуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын 2015 оны 12 дугаар сард байгуулсан Сургалтын хамтарсан тэтгэлгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дээд боловсролын хамтарсан тэтгэлэгийн хөтөлбөрийн хүрээнд хавсралтад нэр дурдсан 5 иргэнийг 2019-2020 оны хичээлийн жилээс Бүгд Найрамдах Франц Улсын их дээд сургуулийн магистрантур, докторантурт суралцуулсугай.

2. Холбогдох байгууллагын нэхэмжлэхийн дагуу суралцагчидтай гэрээ байгуулж төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /М.Ариунжаргал/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Гадаад хамтын ажиллагааны газар /Д.Гарди/-т тус тус даалгасугай.

САЙД



Е.БААТАРБИЛЭГ



Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын
2019 оны 07 дугаар сарын 31-ны өдрийн
40/188 оот тушаалын хавсралт

Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр БНФУ-ын тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд
магистрантур, докторантурын сургалтад хамрагдах иргэдийн нэр

№	Овог/Нэр	Сургууль Мэргэжил	Суралцах түвшин	Суралцах хугацаа
1	Дарамбазар Гандорж	Université Haute-Alsace /These doctorale sur les réseaux électriques/	Доктор	3 жил
2	Отгонбаатар Мандухай	Unversité Nice Sophia Antipolis /mathématique pures et appliquées/	Магистр	1 жил
3	Од-Эрдэнэ Бум-Эрдэнэ	Université de Strasbourg /design projet/	Магистр	2 жил
4	Энх-Амгалан Номиндарь	HEY-YNCREA /Science and engineering - Smart Cities/	Магистр	2 жил
5	Сэнгэдорж Аззаяа	Institut polytechnique de Grenoble /nanosciences-nanomedicine/	Магистр	1 жил